Нэгж сэдэв: Монгол амар яруу найраг
Ээлжит хичээлийн сэдэв: Зүйр цэцэн үг
Ээлжит хичээлийн зорилго: Зүйр үгийн утгыг ойлгож, хэрэглэх

Хэрэглэгдэхүүн:

- Сурах бичиг
- PPT
- Жишээ захидал










Өгсөн зурагт тохирох зүйр үгийг олж бичээрэй.

# Зүйр цэцэн үг гэж юу вэ?

Зүйр цэцэн үг бол хүний аж төрөх ёс зан үйл, амьдралын олон талтай үзэгдэл юмсыг нэг төрлийн адил ойролцоо төрх байдлаар адилтган зүйрлэж, далдуур утгаар хүний сэтгэл хөдлөм дүрслэлтэй мэргэн цэцэн үгээр илэрхийлдэг хэвшмэл хэллэг юм.
Хоёр буюу дөрвөн мөрөөр үгийн толгой ба сүүл эцсийн үеийг холбож шүлэглэсэн хэлбэртэй байдаг байна. Агуулгын хувьд өргөн бөгөөд утга төгөлдөр, хэлбэрийн хувьд богино бөгөөд утга адилтган жишсэн чанар бүхий зохиомжтой байдаг учраас хүнд нөлөөлж, хүнийг амьдрал тэмцэлд сурган заах онцлог шинжтэй





Дараах онолын ойлголтыг дэвтэртээ бичээрэй.

### В. Хүний харилцаа, зан чанар, нэр төр, үг хэл, өөрийгөө таних тухай

Гэгээн ухаантан гэмээ мэддэг
Саруул ухаантан саараа мэддэг

Цэцэн хүн хүний бэрхийг магтдаг
Тэнэг хүн өөрийн бэрхийг магтдаг

Онгироо хүн олонд хүндгүй
Оготор хормой жаварт номоргүй

Тайлбаргүй хүн шантрах нь амархан
Тугалган жад шамрах нь амархан

---

Ховдог хүн хон хэрээтэй адил
Хэрүүлч хүн омхий хүрэнтэй адил
Нэр хугарахаар
Яс хугар
Орчлонг өргөстэй гэвэл гутлаа сайн углa
Олныг буруутай гэвэл өөрийгөө сайн шинж
Нөхрөө харж биеэ зас
Сүүдрээ харж бүсээ зас
Агт алдвал барьж болдог
Ам алдвал барьж болдоггүй
Үг давтвал үлиг
Ном давтвал билиг

Үг сөрвөл хэрүүл
Үүл сөрвөл бороо
Зөөлөн үгэнд хүн бөхийнө
Зүлэг газарт морь бөхийнө
Ховын үгэнд хол ойр гэж үгүй
Хорт могойд бүдүүн нарийн гэж үгүй
Айл хүний амь нэг
Саахалт айлын санаа нэг
Эрхий хуруу эрдэмтэй ч
Чигчий хуруугүй бол дутмаг
Цуварч явсан барсаас
Цуглаж суусан шаазгай дээр

### А. Ажил хөдөлмөр, хичээл зүтгэл, арга эв, сурч мэдэхийг эрхэмлэх тухай

Мэдье гэвэл мэрий
Чадья гэвэл чармай

Сурахын дайсан бардамнах
Явахын дайсан залхуурах

Эрдэнэ ховор боловч олж болдог
Эрдэм гүн боловч сурч болдог

Ажил хийж хүн болдог
Ар давж хүлэг болдог

Ажилд дадлага
Ачаанд татлага

Аргыг олбол
Бэрхийг давна

Ажилч хүн амны хишигтэй
Залхуу хүн зaяа муутай

Бага залхуугаас
Их залхуу болох

Эрт босвол нэгийг үзнэ
Орой унтвал нэгийг сонсоно

Алдыг нь авaад дэлэм дээр нь
Атгыг нь авaад чимх дээр нь

Усны гүнийг уургаар мэдэх
Ухааны гүнийг үгээр мэдэх

Ажил хийвэл ам тосодно

Дуудах нэрийг эцэг эх
Дуурсах нэрийг өөрөө

Буруу замаар будаа зөөсөн хүн
Буцахдаа шороо зөөнө

Хүн хэлээрээ, мал хөлөөрөө

### Б. Ач тус, зөв буруу, ёс журмыг сахих тухай

Ахаа алд хүндэл
Дүүгээ дэлэм хүндэл

Ам нь идэж, сүүл нь таргалдаг
Ах нь сургаж, дүү нь сонсдог

Ахмадаа хүндлэх нь цэцний шинж
Арсалдаж маргах нь тэнэгийн шинж

Бороотой боловч болзоондоо
Хуртай боловч хугацаандаа

Өөрийн тусыг эхэнд нь
Нөхрийн тусыг сүүлд нь

Буруу юм багадахгүй
Зөв юм ихдэхгүй

Их малгай толгой дарна
Их зан бие дарна

Ааш зангийн номхон нь сайн
Адуу малын тарган нь сайн

Би гэсэн ганцаараа
Бид гэсэн олуулаа

Шунал ихэдвэл шулам болно
Шуурга ихэдвэл зуд болно

Өөрийгөө өмөөрөхдөө
Өндгөө дарсан шувуу шиг

Хүнийг хэлэхдээ
Хүрэн эрээн бүргэд шиг



# Зүйр цэцэн үгийг уншаарай.

### В. Хүний харилцаа, зан чанар, нэр төр, үг хэл, өөрийгөө таних тухай

Гэгээн ухаантан гэмээ мэддэг
Саруул ухаантан саараа мэддэг

Цэцэн хүн хүний бэрхийг магтдаг
Тэнэг хүн өөрийн бэрхийг магтдаг

Онгироо хүн олонд хүндгүй
Оготор хормой жаварт номоргүй

Түйлбаргүй хүн шантрах нь амархан
Туглалган жад шамрах нь амархан

Ховдог хүн хон хэрээтэй адил
Хэрүүлч хүн өмхий хүрэнтэй адил
Нэр хугарахаар
Яс хугар
Орчлонг өргөстэй гэвэл гутлаа сайн угла
Олныг буруутай гэвэл өөрийгөө сайн шинж
Нөхрөө харж биеэ зас
Сүүдрээ харж бүсээ зас
Агт алдвал барьж болдог
Ам алдвал барьж болдоггүй
Үг давтвал үлиг
Ном давтвал билиг

Үг сөрвөл хэрүүл
Үүл сөрвөл бороо
Зөөлөн үгэнд хүн бөхийнө
Зүлэг газарт морь бөхийнө
Ховын үгэнд хол ойр гэж үгүй
Хорт могойд бүдүүн нарийн гэж үгүй
Айл хүний амь нэг
Саахалт айлын санаа нэг
Эрхий хуруу эрдэмтэй ч
Чигчий хуруугүй бол дутмаг
Цуварч явсан барсаас
Цуглаж суусан шаазгай дээр

### А. Ажил хөдөлмөр, хичээл зүтгэл, арга эв, сурч мэдэхийг эрхэмлэх тухай

Мэдье гэвэл мэрий
Чадья гэвэл чармай

Сурахын дайсан бардамнах
Явахын дайсан залхуурах

Эрдэнэ ховор боловч олж болдог
Эрдэм гүн боловч сурч болдог

Ажил хийж хүн болдог
Ар давж хүлэг болдог

Ажилд дадлага
Ачаанд татлага

Аргыг олбол
Бэрхийг давна

Ажилч хүн амны хишигтэй
Залхуу хүн заяа муутай

Бага залхуугаас
Их залхуу болох

Эрт босвол нэгийг үзнэ
Орой унтвал нэгийг сонсоно

Алдыг нь аваад дэлэм дээр нь
Атгыг нь аваад чимх дээр нь

Усны гүнийг уургаар мэдэх
Ухааны гүнийг үгээр мэдэх

Ажил хийвэл ам тосодно

Дуудах нэрийг эцэг эх
Дуурсах нэрийг өөрөө

Буруу замаар будаа зөөсөн хүн
Буцахдаа шороо зөөнө

Хүн халзарвал, мал хөлөөрөө

### Б. Ач тус, зөв буруу, ёс журмыг сахих тухай

Ахаа алд хүндэл
Дүүгээ дэлэм хүндэл

Ам нь идэж, сүүл нь таргалдаг
Ах нь сургаж, дүү нь сонсдог

Ахмадаа хүндлэх нь цэцний шинж
Арсалдаж маргах нь тэнэгийн шинж

Бороотой боловч болзоондоо
Хуртай боловч хугацаандаа

Өөрийн тусыг эхэнд нь
Нөхрийн тусыг сүүлд нь

Буруу юм багадахгүй
Зөв юм ихдэхгүй

Их малгай толгой дарна
Их зан бие дарна

Ааш зангийн номхон нь сайн
Адуу малын тарган нь сайн

Би гэсэн ганцаараа
Бид гэсэн олуулаа

Шунал ихэдвэл шулам болно
Шуурга ихэдвэл зуд болно

Өөрийгөө өмөөрөхдөө
Өндгөө дарсан шувуу шиг

Хүнийг халахдаа
Хүрэн эрээн бүргэд шиг



**Зүйр цэцэн үг бүрийн утгыг тайлбарлаж ярилцаарай.**

# Захидал бичихдээ:

- Сургаалын зохиолоос эшлэн оруулж бичсэн дараах захидлаас санаа аваарай.
- Захидлыг хэн найздаа зориулж бичээрэй.
- Зүйр цэцэн үгээс сонгосноо хэрэглэх



Эрхэм дүү Сүрэнжавын амрыг эрье! Бид сайн явж ирлээ.

Ээж нь хүүхдэдээ, эгч нь дүүдээ бичихийн адил энгийн бөгөөд шулуун үг надаас гарахаас биш хан тэнгэрийн оргилд эс гаргаж, хаан титэм үл өмсгөнөм, чамд. Алт сувд агуурс тэргүүтнийг хэчнээн хураавч ертөнцийн ариун баялгийг ер нэгэн авч чадахгүй учир шунах сэтгэл хэзээ ч үл ханадаг. Түүн лүгээ жишихэд хэн нэгэн хэчнээн авьяастай ч орчлонгийн түг түмэн хүний хүслийг ганцаараа хэзээ ч үл хангах. Зоригоор хэдий их аашлах тусам замаас гажихын цондон болох. Сайн хүнээ сэтгэл дотроо сансрын өндөрт хүртэл магтавч нүүрэн дээр нь зөвхөн дээвэр хүртэл магтан сайшаадаг нь нисчих вэ гэж айсных байдаг.

Энэ мэт юм бодон амрахаа мэддэггүй шуугиант Европын гудамжийг харж, гайхаж сууна. Нар салхинд хэзээ ч ганддаггүй нутаг юугаа бодон, сэтгэлээ явуулан бэлчээнэм.

Баяртай! 4 сарын 16-нд очно.

С.Удвал,
1980.04.09